



ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ДҮН

2018.04.20

Төсвийн тухай хуулийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3, 18.2 дахь заалтын дагуу аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулан, аймгийн Засаг даргад гардуулан өглөө.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагын мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа:

Ангилал	Нийт тоо	Дүгнэлт гаргасан	Хувийн аудитын компани /Дүгнэлт гаргасан/	Итгэл үзүүлсэн	Түүвэрт хамруулсан
Төсвийн ерөнхийлөн захирагч	1	1			
Сумдын нэгтгэсэн тайлан, нийгмийн даатгалын нэгтгэсэн тайлан	15	15			
Төсвийн шууд захирагч	113	29	8	11	65
Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан	48	1			47
Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж /тоогоор/	19	2	16		
Дүн	196	48	24	11	112

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт **4,306.2** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад залруулж болох **1,194.8** сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Аудитын явцад илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчлийг арилгахын тулд дөрвөн төрлийн арга хэмжээ авдаг. Орлого дутуу төвлөрүүлсэн, мөнгөн хөрөнгө дутсан мөн улсад болон байгууллагад хохирол учруулсан тохиолдолд акт тавьдаг. Тиймээс төсөвт буцааж төвлөрүүлэх шаардлагатай гэсэн үг. Харин шалгагдагч байгууллагын удирдлагаас богино хэмжээнд авч хэрэгжүүлэх нь тухайн алдаа дутагдлыг таслан зогсоох дахин давтахгүй байхад чухал нөлөөтэй гэж үзвэл албан шаардлага хүргүүлдэг. Акт, албан шаардлага бол зайлшгүй биелэгдэх шинж чанартай. Харин тухайн үйл ажиллагаа болон тайлагналыг сайжруулахын тухайд зөвлөмж өгдөг. Мөн хууль тогтоомж зөрчсөнөөс гадна гэмт хэргийн шинжтэй байх магадлалтай зөрчлийг холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулдаг. Тэгэхээр **3,111.4** сая төгрөгийн алдаа зөрчлүүдэд дээрх арга хэмжээг авсан.

2,111.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, хохирлыг нөхөн төлүүлэхээр 485.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахаар 43 заалт бүхий 61.3 сая төгрөгийн зөвлөмжийг тус тус өглөө.

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулсан асуудлууд

2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад хууль тогтоомж зөрчсөнөөс гадна гэмт хэргийн шинжтэй байх магадлалтай нийт 43.6 сая төгрөгийн 4 асуудлыг Авлигатай тэмцэх газар болон аймгийн Цагдаагийн газарт шилжүүллээ.

Хариуцлага тооцоулах албан шаардлага, ажлаас халах санал

Сахилгын шийтгэл ногдуулах санал: Өмнөх аудитаар хугацаа хэтрэлттэй зээлийн үлдэгдлийг барагдуулахаар өгсөн 442.5 сая төгрөгийн төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй Адаацаг, Гурвансайхан, Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өлзийт сумдад Төрийн аудитын тухай хуулийн 28.2¹-т заасны дагуу хариуцлага тооцох саналыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” байгууллагын дарга, нягтлан бодогч нарыг ажлаас халах саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүллээ.

Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага: Аудитад ТЕЗ-ийн харьяаны 196 төсөв захирагчийн санхүүгийн тайлан хамрагдахаас Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар батлагдсан журмын дагуу шалгуур хангасан 11 байгууллагад итгэл үзүүлж, аудит хийлгүй өнжөөсөн, үйл ажиллагаа явуулаагүйгээс Хот тохижуулах газар ОНӨААТҮГ-т аудит хийгдээгүй. Үлдсэн

184 санхүүгийн тайлангаас түүвэрт хамруулан шалгасан 112, бие даасан дүгнэлт гаргасан 72 байгаагаас 63 байгууллагад “Зөрчилгүй”, 8 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1

Дүгнэлтийн ангилал	Зөрчилгүй	Хязгаарлалт -тай	санал дүгнэлт гаргахаас татгалзсан
Төсвийн байгууллага	45	8	-
Төсөл, хөтөлбөр /ЗГТС+ОНТЗС/	1	-	-
ТБОНӨААН	17	-	1
Дүн	63	8	1

байгууллагад “Санал дүгнэлт өгөхөөс татгалзах” санал дүгнэлт гаргажээ. /Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төв, Өндөршил сумын ЗДТГ, Номын сан, Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төв, Адаацаг сумын Эрүүл мэндийн төв, Баянжаргалан сум, Цагаандэлгэр сум, Гурвансайхан сумын нэгтгэсэн тайлан, Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ/

¹ 28.2. Дараах тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ:

28.2.1.аудитад хамрагдсан байгууллагын санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллагаас санал, дүгнэлт өгөх боломжгүй тохиолдолд;

28.2.2.төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд.

Санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй”, “Хязгаарлалттай”, “Сөрөг”, “Дүгнэлт өгөхөөс татгалзах” гэсэн 4 төрлийн дүгнэлт өгдөг. “Хязгаарлалттай” болон “Сөрөг” санал дүгнэлт авсан байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцох албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлдэг. Харин “Дүгнэлт өгөхөөс татгалзах” санал дүгнэлт авсан байгууллагын дарга, нягтлан бодогч нарыг ажлаас халах саналыг хүргүүлдэг.

“Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан 5 байгууллагуудын дарга, нягтлан бодогч, 3 сумын Засаг дарга, Санхүүгийн албаны дарга нарт буюу 16 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлээд байна.

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР